



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 11. 27 № ХТТ/2571
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Монгол орны ойн сангийн төлөв байдал, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ¹³..... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000235025120

МОНГОЛ ОРНЫ ОЙН САНГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЯВЦ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Монгол орны ойн сангийн төлөв байдал

Монгол орны ой Сибирийн их тайга, Төв-Азийн хээр, цөлийн торгон заагт уур амьсгалын эрс тэс нөхцөлд тархан ургах тул байгалийн аясаар тэлэн ургах боломж нэн хязгаарлагдмал, ой бүтээмж, өсөлтийн хувьд бага, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчин болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртөмтгий эмзэг экосистем юм. Мөн гол, мөрний усны нөөцийг зохицуулах, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих, цөлжилтийг сааруулах зэрэг экологийн өндөр ач холбогдолтой.

Монгол Улсын ойн сан нутгийн хойд хэсгийг эзлэх шилмүүст, навчит ой, нутгийн өмнөд талын говь цөлийн бүсээр тархан ургах заган ойгоос бүрдэнэ. Үүний 74.6 хувийг навчит, шилмүүст ой, 25.3 хувийг заган ой эзэлдэг.


Ойн сангийн талбай 2022 оны байдлаар 18,596.1 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.89 хувийг эзэлж байна. Ойн сангийн талбайг газрын төрлийн ангиллаар харвал ойгоор бүрхэгдсэн газар (байгалийн ой, бут сөөг, таримал ой) 12,619.4 мянган га (67.8 хувь), ойгоор бүрхэгдээгүй буюу тармаг мод 3,399.2 мянган га (18.28 хувь), шатсан талбай 1,646.2 мянган га (8.85 хувь), мод бэлтгэсэн талбай 130.7 мянган га (0.7 хувь), ойжих талбай 151.7 мянган га (0.82 хувь), ойжуулсан талбай 25.8 мянган га (0.14 хувь), ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай 102.2 мянган га (0.55 хувь), салхи, цасанд унасан ойн талбай 0.4 мянган га (0.0002 хувь), ойн бус талбай 520.4 мянган га (2.8 хувь) талбайг тус тус хамаарна.

Ойн сангийн талбайн хэмжээ нийт газар нутагтай харьцуулахад бага (11.89 хувь) боловч 1 хүнд ногдох ойн талбай 5.4 га/хүн байгаа нь дэлхийн дундаж үзүүлэлт (0.54 га/хүн)-ээс хавьгүй өндөр байдаг.

Ойн сангийн талбай, мянган га (2012-2022 он)

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Ойгоор бүрхэгдсэн	12519	12174.7	12280	12290	12392.8	12392.8	12421.4	12452	12619.4	12619.4
Ойгоор бүрхэгдээгүй	5233.2	5603.1	5631.1	5625.3	5645.9	5645.9	5633.2	5634.4	5456.3	5456.3
Ойн бус	905.8	543.5	543.5	543.8	554	554	534.7	521.6	520.4	520.4
Нийт	18658	18321.3	18454.6	18459.1	18592.7	18592.7	18589.3	18608	18596.1	18596.1
Ойрхог чанар, %	8.0	7.8	7.8	7.9	7.9	7.9	7.9	8.0	8.07	8.07

Ойн сангийн талбайн газрын төрлийн эзлэх хувь




Аливаа улс орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайг нийт нутаг дэвсгэрт харьцуулж хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ойрхог чанар гэдэг бөгөөд манай улсын энэ үзүүлэлт 8.07 хувь байна.

Ойн сангийн 2022 оны талбайг 2020 оныхтой харьцуулахад ойгоор бүрхэгдсэн талбай 167.4 мянган га-аар нэмэгдэж, ойрхог чанарын эзлэх хувь 0.07 хувиар өссөн байна.

Ойн сангийн нөөц

Монгол орны ойн нийт нөөц 1,246.6 сая м.куб бөгөөд үүний 79.3 хувийг шинэс, 8.91 хувийг хуш, 6.0 хувийг хус, 5.0 хувийг нарс, 0.2 хувийг гацуур, 0.01 хувийг жодоо, 0.17 хувийг улиас, 0.05 хувийг улиангар, 0.01 хувийг хайлаас, 0.3 хувийг бургас, 0.16 хувийг заг, тоорой тус тус эзэлж байна. Шилмүүст мод зонхилсон ойн дундаж нас 131 жил, 1 га-ын нөөц 142.8 м.куб, өсөлт 1.1 м.куб, навчит мод зонхилсон ойн дундаж нас 43 жил, 1 га-ын нөөц 44.4 м.куб, өсөлт 1.02 м.куб, жилийн бүх дундаж өсөлт 10,215.4 мянган м.куб байна.

Байгалийн ойн талбайн нөөц, сая м.куб



Байгалийн ойн нөөц (2013-2022 он, модны төрлөөр, сая м.куб)

Модны төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Шинэс	1,304.7	977.1	977.3	978.1	985.9	985.9	990.3	989.9	988.4	988.4
Нарс	63.8	61.8	61.8	62.1	62.1	62.1	61.9	61.7	61.8	61.8
Хуш	120.8	116.1	116.1	116.9	116.9	116.9	116.5	111.2	111.2	111.2
Гацуур	3.6	2.9	2.8	2.8	2.8	2.8	2.8	2.8	2.8	2.8
Жодоо	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2
Хус	81.9	76.8	76.8	76.8	76.2	76.2	75.4	74.4	74.3	74.3
Улиас	2.5	2.2	2.2	2.2	2.2	2.2	2.2	2.2	2.1	2.1
Улиангар	1.1	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.6	0.7	0.7	0.7
Хайлаас	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1
Бургас	3.5	3.4	3.4	3.4	3.5	3.5	3.5	3.5	3.1	3.1
Заг	1.8	1.8	1.8	1.8	1.8	1.8	1.8	1.8	1.9	1.9
Тоорой	0.01	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.02	0.03	0.04	0.04
НИЙТ	1,313.7	1,243.2	1,243.4	1,245.4	1,252.5	1,252.5	1,255.3	1,248.6	1,246.6	1,246.6

Ой хээрийн түймэр

Улсын хэмжээнд 2021-2022 онд 173 удаагийн ой, хээрийн түймэр гарч, 16 мянган га ой, 117 мянган га хээр, нийт 133 мянган га талбай өртжээ. Түймрийн улмаас 12.5 тэрбум төгрөгийн экологийн хохирол учирч, түймрийг унтраахад 360.9 сая төгрөгийн зардал гарч, нийт хохирол 13.2 тэрбум төгрөг болжээ. Ой, хээрийн түймрийн 2021-2022 оны мэдээг 2019-2020 онтой харьцуулахад түймрийн тоо 31 тохиолдлоор, түймэрт өртсөн талбайн хэмжээ 111 мянган га-аар, хохирлын хэмжээ 11.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Ойн түймрийн мэдээлэл

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Түймрийн тоо											
Түймэр	229	198	281	354	138	225	77	121	142	65	173
Нийт өртсөн талбай, мян.га											
Ой	341	5.8	18.3	31	17	121	16.6	50	10	2	16
Хээр	4700	5601.9	3080.8	5817	4700	467	552.0	262	235	202	117
Нийт	5050	5607.7	3099.1	5847.9	4717.1	587.5	568.6	312	244	204	133
Хохирол, тэрбум.төг											
Нийт	84	7	11	6	9	78	40	24	1	3	13
Экологийн	82	5	10	6	8	77	39	24	1	3	12.4


Ойн нөөцийн ашиглалт

Ойн тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд тухайн жилд ойгоос бэлтгэж ашиглах модны дээд хязгаарыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын судалгаагаар тогтоосон тооцоот

хэмжээг үндэслэн аймаг, нийслэлээр тогтоож, энэ хязгаарт багтаан аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргээр, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аж ахуйн нэгж, байгууллагаар тогтоодог.

Ойн нөөцийн ашиглалтын мэдээлэл

Он	2017	2018	2019	2020	2021	2022
Нийт бэлтгэсэн (мянган м.куб)	720.9	664.0	777.1	776.5	777.5	720.7
Тогтоосон дээд хязгаар (мянган м.куб)	1809.6	1351.1	1387.4	1437.9	1217.7	1377.8
Төсөвт орсон орлого (сая төгрөг)	3057.4	3130.6	3583.2	3595.1	6996.5	5707.7



Ойн сангийн хамгаалагдсан байдал

Ойн сангийн нийт талбайн 6,642.6 мянган га буюу 35.7 хувь нь тусгай хамгаалалттай газар нутагт, 8,812.6 мянган га буюу 47.4 хувь нь бусад хамгаалалтын бүсэд, 3,141.1 мянган га буюу 16.9 хувь нь ашиглалтын бүсэд тус тус хамаарагдаж байна.

Улсын хэмжээнд 651 ойн мэргэжлийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Ойн мэргэжлийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих тооны мэргэжлийн мэргэшсэн ажилтан ажиллуулах болон орчин үеийн технологи, техник хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжгүй тул техник хэрэгслийг бие биенээс түрээслэх хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Иймд эдийн засгийн үр ашгийг тооцон жижиг аж ахуйн нэгжийг нэгтгэх замаар тоог багасгаж, магадлан итгэмжлэлийн системд шилжүүлэн, орчин үеийн ойн техник худалдан авахад татаас өгөх, урт хугацааны зээл олгох зэргээр дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Хоёр. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн явц

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх эх дэлхий, байгаль орчноо хайрлан, зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэх талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийг гаргасан билээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар тодотгон танилцуулъя.

1. Байгаль орчин, түүний дотор ойн салбарын тулгамдсан асуудал, ойн хомсдол, нөхөн сэргээлтийн асуудлыг олон улсын болон Монгол Улсын хэмжээнд өндөр түвшинд гаргав.

➤ Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд олон улсад хамтын ажиллагааны олон ажлууд хийгдсээр байна. Тухайлбал, Европын Холбооноос олон улсын хэмжээнд санаачлан гаргасан “Ойн түншлэл”-д нийт 5 улс багтсан ба Ази, Номхон Далайн бүсээс Монгол Улс ганцаараа багтаж байгаа юм.

Ойн түншлэл нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, үүнтэй уялдуулан ойн салбарт учирч буй сорилт, бэрхшээлийг даван туулах, улс орны хөгжлийн хэрэгцээ шаардлага, байгаль орчныг хамгаалах зорилтод чиглэсэн үүрэг, амлалт юм.

2022 оны 11 дүгээр сард Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Шарм Эль-Шейх хотод болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх болон Европын Комиссын Ерөнхийлөгч Урсула Фон Дер Лайен нар “Ойн түншлэлийн тухай Монгол Улс болон Европын Холбоо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурсан.

Тус санамж бичгийг хэрэгжүүлэх хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн газар болон Европын Холбооноос Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газар хамтран 2023 оны 1 дүгээр сараас “Замын зураг”-ын төслийг хэлэлцэн тохиролцох ажлыг гүйцэтгэж эхэлсэн. Энэ хугацаанд аймаг, сумын ойн газар болон аймгуудын БОАЖГ-ын төлөөллүүдэд “Замын зураг”-ын төслийг танилцуулах, орон нутгийн байгууллагуудын оролцоог хангах, мэдээлэл дамжуулах зорилго бүхий уулзалт, мөн шинжлэх ухааны болон мэргэжлийн төрийн бус байгууллагууд зэрэг бусад оролцогчидтой хийх уулзалтыг тус тус зохион байгуулж, санал, хүсэлт, зөвлөмжийг тусган ажилласан.

Санамж бичгийн хүрээнд 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Европын холбооноос Монгол Улсад суугаа бүрэн эрхт Элчин сайд нарын даргалдаг Бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн анхдугаар хуралдаан болж, “Замын зураг”-ийг хоёр тал эцэслэн баталлаа. Ингэснээр санамж бичиг байгуулагч талууд хэрэгжүүлэх арга хэмжээндээ шилжин, төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааг эхлүүлсэн болно.

➤ Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн тэргүүн нарын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай” хамтарсан мэдэгдлийн хүрээнд Монгол Улсын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих, Монгол-Хятадын цөлжилтийг сааруулах хамтын ажиллагааг өргөжүүлэх, түлхэц үзүүлэх зорилгоор Монголын талын урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг болон Үндэсний ойн аж ахуй, бэлчээрийн газрын 14 хүний бүрэлдэхүүнтэй судалгааны баг 2023 оны 06 дугаар сарын 26-аас 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллав.

Хятадын талын судалгааны багийн бүрэлдэхүүн үндсэн 3 багт хуваагдан ажилласан. 1 дүгээр баг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох яамд болон эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн төлөөллүүдтэй уулзах, хамтарсан төвийн барилгын талбар, цөлжилтийг сааруулах технологийн туршилтын талбар байгуулах газрыг сонгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

Харин 2 дугаар баг Монгол Улсын зүүн өмнөд, зүүн, баруун өмнөд болон хойд хэсэгт, 3 дугаар баг өмнөд, баруун өмнөд хэсэгт Ойн газар болон Шинжлэх ухааны академийн Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран ажилласан. Хээрийн судалгааны явцад тухайн бүс нутгийн газрын доройтол, цөлжилтийн төлөв байдалтай газар дээр нь танилцахын зэрэгцээ Монгол Улсад цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах чиглэлд хийж хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсөл, хөтөлбөртэй танилцав.

Дээрх айлчлалуудын үр дүнд Монгол-Хятадын цөлжилттэй тэмцэх хамтын ажиллагааны төв байгуулах ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан санамж бичигт гарын үсэг зурах, хэлэлцээр хийх зорилго бүхий Хятадын Үндэсний ойн аж ахуй, бэлчээрийн газрын дэд захирал болон Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (CIDCA)-ын тэргүүнээр ахлуулсан баг бүрэлдэхүүн 2023 оны 8 дугаар сарын 30-аас 9 дүгээр сарын 5-ны өдрийг хүртэл Монгол Улсад ажилласан.

Монгол Улсад ажиллах хугацаанд талууд хамтын судалгааны ажлаар дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

- Цөлжилттэй тэмцэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны ажлын хэсгийн түр байрлах ажлын албан өрөөг сонгох, хаягжуулах;
- Цөлжилттэй тэмцэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны төвийн анхан шатны төлөвлөгөөг хэлэлцэх, шинээр байгуулах төвийн газрыг сонгох;
- Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах технологи туршилт, үзүүлэнгийн талбайн байршил сонгох;
- Цөлжилт, шороон шуурганы эх үүсвэрийн хяналтын цэгүүдийг байгуулах, цэгийн байршлын тандан судалгаа хийх;
- Цөлжилттэй тэмцэх хамтарсан судалгааг эхлүүлэх;
- Материаллаг тусламж, чадавхыг бэхжүүлэх (мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, богино хугацааны сургалт зохион байгуулах, мэргэжилтэн солилцох гэх мэт);
- Цөлжилттэй тэмцэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны төвийг байгуулах хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулах талаар хэлэлцэх
- Улмаар 2023 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Монгол-Хятадын хамтын ажиллагааны ажлыг дүгнэх уулзалтыг тус тус зохион байгууллаа.

2. Ойн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох ажлуудыг зохион байгуулав.

➤ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнд хүргэх, амжилттай хэрэгжүүлэх нэг гол тулгуур байгууллага нь орон нутаг дахь сум дундын болон сумын ойн анги юм. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 42 сум дундын ойн анги, 4 сумын ойн анги ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, зүй зохистой ашиглах, ойн тогтвортой менежментийг сайжруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Энэ оны эхнээс Дорнод аймгийн Халхгол сум, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Сэврэй сумуудад сум дундын ойн анги байгуулан үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

➤ Ойн ангиудын үйл ажиллагаанд хянан магадалгаа хийх ажлыг Төв аймгийн Лүн, Батсүмбэр, Мөнгөнморьт, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон, Булган сумдын ойн ангиудыг хамруулан явууллаа.

➤ Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.22, 14.3.23, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Ойн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/233 дугаар тушаалаар баталсан “Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам”-ын хэрэгжилт болон боловсон хүчин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, арга зүйн бүрдлийг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор Улаанбаатар хот, 10 аймагт үйл ажиллагаа явуулж байгаа “ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх”, “ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах”, “байгалийн дагалт баялгийг хамгаалах, ашиглах” ойн мэргэжлийн байгууллагуудад түвшин тогтоох үзлэгийг зохион байгуулж, үйл ажиллагаа явуулж байгаа 516 ойн мэргэжлийн байгууллагаас 450 буюу 87.2 хувь нь хамрагдлаа.

3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн ажлуудын тоон мэдээлэл

➤ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнд хүргэх, амжилттай хэрэгжүүлэх гол үндэс суурь нь мод үржүүлгийн газруудыг дэмжих, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх ажил юм. Энэ хүрээнд улсын хэмжээнд мод үржүүлгийн газруудын бүртгэл, тарьц, суулгацын нөөцийн хэмжээг тодорхойлох ажлыг зохион байгууллаа.

Тооллогоор улсын хэмжээнд 452 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж байгаагаас 76 иргэн, 25 нөхөрлөл, 351 аж ахуй нэгж, байгууллага нийт 21 овог, 52 төрөлд багтах 124 зүйлийн 62,978,816 ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүлсэн байна. Энэ нь өмнөх жилийнхтэй харьцуулахад даруй 5 дахин өссөн үзүүлэлт бөгөөд үүнээс дүгнэхэд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх бүрэн боломжтой байна.

Тарьц, суулгацын нөөцийн мэдээлэл

№	Аймгийн нэр	Тоо хэмжээ				Тарьц, суулгацын тоо (ширхэг)
		ААН	Иргэн	Нөхөрлөл	Нийт	
1	Архангай	7	1	1	9	192,521
2	Баян-Өлгий	4	2	0	6	874,500
3	Баянхонгор	10	0	0	10	380,536
4	Булган	21	7	0	28	3,870,014

5	Говь-Алтай	6	3	0	9	374,090
6	Говьсүмбэр	5	0	0	5	115,467
7	Дархан-Уул	16	3	2	21	2,565,702
8	Дорноговь	4	0	0	4	316,790
9	Дорнод	17	3	0	20	2,585,124
10	Дундговь	3	-	-	3	522,260
11	Завхан	21	2	0	23	850,694
12	Орхон	8	7	0	15	1,442,973
13	Өвөрхангай	19	1	0	20	5,772,307
14	Өмнөговь	16	0	0	16	2,956,007
15	Сүхбаатар	5	0	0	5	543,510
16	Сэлэнгэ	65	10	16	91	19,645,432
17	Төв	28	0	0	28	12,947,114
18	Увс	18	32	2	52	1,503,782
19	Улаанбаатар	32	0	0	32	2,965,958
20	Ховд	23	5	4	32	1,168,470
21	Хөвсгөл	13	0	0	13	254,870
22	Хэнтий	10	0	0	10	1,130,695
НИЙТ ДҮН		351	76	25	452	62,978,816

➤ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 41.5 сая мод тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж байна.

№	Байршил/Байгууллага	Тарьсан модны тоо			ДҮН
		2021-2022	2023 оны хавар	2023 оны намар	
1	Архангай	496,017	66,425	21,945	584,387
2	Баян-Өлгий	172,964	42,086	167,821	382,871
3	Баянхонгор	211,808	58,526	55,074	325,408
4	Булган	743,899	262,161	366,430	1,372,490
5	Говь-Алтай	76,916	81,716	20,232	178,864
6	Говьсүмбэр	54,251	29,473	42,946	126,670
7	Дархан-Уул	197,944	271,379	47,121	516,444
8	Дорноговь	289,540	93,582	60,886	444,008
9	Дорнод	548,556	160,020	327,440	1,036,016
10	Дундговь	122,884	61,847	27,042	211,773
11	Завхан	303,000	55,926	476,271	835,197
12	Орхон	1,234,847	348,527	1,539,541	3,122,915
13	Өвөрхангай	320,000	236,353	326,466	882,819
14	Өмнөговь	343,759	224,620	319,790	888,169
15	Сүхбаатар	603,402	81,349	77,731	762,482
16	Сэлэнгэ	2,198,813	1,427,955	1,096,354	4,723,122
17	Төв	1,172,292	389,659	1,331,870	2,893,821
18	Увс	246,841	55,468	62,382	364,691
19	Улаанбаатар	1,699,499	237,230	112,183	2,048,912
20	Ховд	175,136	93,876	45,136	314,148
21	Хөвсгөл	650,530	183,950	324,317	1,158,797
22	Хэнтий	571,300	250,667	398,000	1,219,967
ДЭД ДҮН		12,434,198	4,712,795	7,246,978	24,393,971

23	“Эрдэнэс таван толгой” ХК	178,000	142,700	51,000	371,700
24	“Оюу толгой” ХХК	50,000	50,000	76,200	176,200
25	“Болдтөмөр Ерөө Гол” ХХК	345,120	500,000		845,120
26	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ		2,810,000	1,214,151	4,024,151
27	“Энержи ресурс” ХХК	93,000	34,274		127,274
28	“Өсөх зоос” ХХК	20,070	56,200	534,500	610,770
29	“Саусгоби сэндс” ХХК	4,000	23,000		27,000
30	“Таван толгой” ХХК	6,000	24,000		30,000
31	“Бадрах энержи” ХХК	5,000	2,000	3,000	10,000
32	“Эрдэнэс Монгол” ХХК	875,756			875,756
33	“Бороо гоулд” ХХК	30,000	39,051	14,860	83,911
34	“Эрдэнэс силвер ресурс” ХХК	294,500	35,000		329,500
35	“Бүрдэл майнинг” ХХК	4,000			4,000
36	“Алтайн хүдэр” ХХК	2,500			2,500
37	“Монголросцветмет” ТӨҮГ	89,500	104,000		193,500
38	“Монполимет групп”	19,000			19,000
39	“Багануур” ХК	10,000		1,000	11,000
40	“МоЭнко” ХХК	20,200	20,000		40,200
41	“Платинум ланд” ХХК	11,500	14,500	18,000	44,000
42	“Шивээ овоо” ХК	3,600		10,000	13,600
43	Тэрбум мод сан, банк, санхүү				200,000
ДЭД ДҮН		2,061,746	3,854,725	2,122,711	8,039,182
44	ХХЕГ		54,000	71,000	125,000
45	ШШГЕГ			1,545,000	1,545,000
46	БХЯ			68,000	68,000
47	ОБЕГ	14,010			14,010
48	Тод ундарга ХХК	7,700		5,500	13,200
49	Улаанбаатар төмөр зам ХНН		20,000		20,000
50	ИНЕГ		9,000	5,000	14,000
51	Экологийн цагдаа		36,823		36,823
52	Цагдаагийн ерөнхий газар	72,856	63,279	60,000	196,135
53	Эрчим хүчний яам, салбарууд	11,800		23,930	35,730
54	Бугант нандин ХХК			3,000,500	3,000,500
55	Бусад санал, санаачилгууд			4,005,772	4,005,772
ДЭД ДҮН		106,366	183,102	8,784,702	9,074,170
НИЙТ ДҮН		14,602,310	8,750,622	18,154,391	41,507,323

➤ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш улсын хэмжээнд 39 зүйлийн мод сөөгийн 12.1 тонн үрийн нөөц бүрдүүлсэн. Энэхүү үзүүлэлт нь өмнөх жилүүдтэй харьцуулахад даруй 4.5 дахин нэмэгдсэн байна. Ойн үрийн чанарын холбогдох стандартуудын дагуу тоймлон үзэхэд дээрх үрийн нөөцөөр 39 төрлийн 291.7 сая ширхэг тарьц, суулгац ургуулах боломжтой юм.

Мод, сөөгийн үрийн нөөц

№	Зүйлийн нэр	Үрийн нөөц (кг)	Ургуулах боломжит тарьц, суулгацын тоо (ширхэг)
1	Нарс	628.2	28,044,643
2	Шинэс	1018.5	36,375,000
3	Хуш	664.5	765,553

4	Жодоо	2.4	54,545
5	Гацуур	11.82	579,412
6	Голт бор	363.7	9,092,500
7	Өрөл	361.9	22,618,750
8	Монос	1388.8	5,341,538
9	Долоогоно	200.3	1,925,962
10	Шар хуайс	1595.7	15,957,000
11	Агч	766.15	6,178,629
12	Гүйлс	1816.1	648,607
13	Буйлс	852	532,500
14	Жигд	388.9	1,080,278
15	Заг	377.8	37,780,000
16	Тэхийн шээг	46.45	3,628,906
17	Чацаргана	77.9	1,498,077
18	Далан хальс	13.8	1,150,000
19	Хус	21.9	27,375,000
20	Хайлаас	1146.8	47,783,333
21	Улиас	4.3	5,375,000
22	Нохойн хошуу	30.6	637,500
23	Харгана	24.8	344,444
24	Тавилгана	34	32,692,308
25	Бусад – 14 зүйл	346	4,325,000
НИЙТ ДҮН			291,784,486

➤ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цахим хуудас, ухаалаг утасны аппликейшн шинээр хөгжүүлэн, таригдсан модны тооллого, мод үржүүлгийн газруудын байршил, тарьц, суулгацын нөөц, үнийн мэдээлэл, мэргэжлийн байгууллагуудын хүчин чадал, мод тарих сонирхол бүхий иргэд болон санхүүжүүлэгч байгууллагын бүртгэл, хяналт, мониторинг гэсэн үндсэн бүтэцтэй системийн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн.

➤ Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 2023 онд 275.0 мянган га талбайд улсын болон орон нутгийн төсөв болон “Рио Тинто” ХХК-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Эрүүл ой” төслийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг сонгомол үйлчилгээтэй, байгальд ээлтэй технологи болох микробиологийн аргаар агаарын хөлөг, үүргийн шүршигч, гэрлэн болон феромонт урхи ашиглан зохион байгуулсан.

Мөн ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох судалгааны ажлыг 15 аймгийн 109 сумын 2.5 сая га талбайд хийж гүйцэтгэв. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулснаар 0.9 тэрбум модыг доройтолд өртөн, хатаж хуурайших эрсдэлээс хамгаалаад байна.

➤ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн төлөөллүүдийг хамарсан баруун бүсийн зөвлөгөөнийг Баянхонгор аймагт, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн төлөөллүүдийг оруулсан зүүн бүсийн уулзалт, зөвлөгөөнийг Дорнод аймагт тус тус зохион байгуулж, үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн зарим шийдвэр, зөвшилцөлд хүрээд байна. Эдгээр уулзалтуудад амлалт авсан уул уурхайн аж ахуйн нэгж, байгууллагууд,

аймгуудын холбогдох байгууллагуудын төлөөлөл, хувийн хэвшил зэрэг оролцогч талуудыг хамруулсан болно.

➤ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор амлалт авсан уул уурхайн аж ахуйн нэгжүүд, банк, санхүүгийн болон төрийн байгууллагуудын төрөлжсөн уулзалтуудыг зохион байгууллаа. Үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор оролцогч талуудыг хамруулсан уулзалтуудыг долоо хоног бүрийн мягмар гарагт зохион байгуулан ажиллаж байна.

4. Хүний нөөц, чадавхыг нэмэгдүүлэх

➤ Улсын хэмжээнд 2023 оны байдлаар ойн мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшихээр 266 оюутан суралцаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд 77 оюутан тус мэргэжлээр шинээр элсэн орсон бол 32 оюутан төгссөн байна.

Энэ хичээлийн жилд мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, сургалтын байгууллагад ойн арчилгаа, ашиглалтын ажилтнаар 528, ойн аж ахуйн ажилтнаар 37, ойн нөхөрлөлийн ажилтнаар 52, ойн техникчээр 11 суралцагч суралцаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд 32 суралцагч техникч мэргэжлээр суралцахаар элсэн орж, 20 суралцагч ойжуулагч мэргэжлээр төгсөөд байна.

Гурав. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.5-д заасан “Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэсэн зорилтыг хангах болон “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд дор дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, гол нууруудын татмыг ойжуулах ажлыг 2.4 мянган га талбайд зохион байгуулж, 3.1 сая мод тарина;
- Ойн зохион байгуулалтын ажлыг 2.8 сая га талбайг хамруулан явуулж, ойн төлөв байдлыг үнэлэх ажлыг зохион байгуулна;
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор түймрийн 500 км халз болон шороон зурвас шинээр байгуулах, өмнө байгуулсан зурвасыг сэргээх ажлыг хийнэ;
- Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг хязгаарлах, тоо толгойн нягтшилыг бууруулах тэмцлийн ажлыг 235.0 мянган га талбайд хамруулан зохион байгуулж, 1.2 тэрбум модыг доройтолд өртөхөөс урьдчилан сэргийлнэ;
- Ойг доройтлоос хамгаалах, түймрийн эрсдэлийг бууруулах зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлыг 1.3 мянган га талбайг хамруулан зохион байгуулна;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилтийг сааруулах хамгаалалтын ойн зурвасыг 130 га талбайг хамруулан зохион байгуулна;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газруудад техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.

➤ Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажлын үр дүн, чанарыг сайжруулж, мод тарьж ургуулахад мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Талбай, га	Тарих модны тоо	Төсөв, сая төг
1	Доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах	300	750,000	2,400.0
2	Говь хээрийн бүсэд ойг нөхөн сэргээх, ойжуулах	340	442,000	4,758.0
3	Хамгаалалтын ойн зурвас байгуулах	115	149,500	1,794.0
4	Байгалийн сэргэн ургалтад туслах	1500	1,500,000	1,110.0
5	Агро ойн аж ахуйн байгуулах	200	270,000	2,190.0
6	Ойг нөхөн сэргээх, мод тарих, бусад арга хэмжээ			8,241.5
ДҮН		2455	3,111,500	20,493.5

Доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын төлөвлөгөө

№	Орон нутаг	Ойжуулалт, га	Ойн зурвас, га	БСУТА, га	Говь хээрийн бүсийг ойжуулах	Нийт дүн
1	Архангай			125		125
2	Баянхонгор		5			5
3	Булган			10		10
4	Говьсүмбэр		10			10
5	Говь-Алтай		10			10
6	Дархан-Уул			50		50
7	Дорнод		10	155		165
8	Дундговь		5			5
9	Завхан	20		120		140
10	Өвөрхангай	20	10		16	46
11	Сүхбаатар		10			10
12	Сэлэнгэ					
13	Төв	28				28
14	Увс		10	50		60
15	Ховд		10			10
16	Хөвсгөл			200		200
17	Хэнтий			90		90
18	Улаанбаатар	20				20
ДҮН		88	80	800	16	984

Говь хээрийн бүсэд ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын төлөвлөгөө

№	Орон нутаг	Доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, га	Говь хээрийн бүсийг ойжуулах, га	Хамгаалалтын ойн зурвас байгуулах, га	Байгалийн сэргэн ургалтад туслах, га	Агро ойн аж ахуйн байгуулах, га	Нийт
1	Архангай	40			150		190
2	Баян-Өлгий			10			10
3	Баянхонгор		40	10		100	150
4	Булган	20			150		170
5	Говьсүмбэр		40	10			50
6	Говь-Алтай		40	10			50
7	Дархан-Уул				150		150
8	Дорнод		40	10	150		200
9	Дорноговь		20				20
10	Дундговь		40	10		100	150
11	Завхан	40			150		190
12	Өвөрхангай	40		10	150		200
13	Орхон			5			5
14	Сүхбаатар		40	10			50
15	Сэлэнгэ	30			150		180
16	Төв	40			150		190
17	Увс		40	10			50
18	Ховд		40	10			50
19	Хөвсгөл	40			150		190
20	Хэнтий	30		10	150		190
21	Улаанбаатар	20					20
НИЙТ ДҮН		300	340	115	1500	200	2455

➤ Ойн хөнөөлт шавжийн голомттой ойн санд тэмцлийн ажил явуулж, ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулан, хомсдол, доройтлыг бууруулж, ойн төлөв байдлыг тогтмол үнэлнэ.

№	Орон нутаг	Тэмцлийн ажлын төлөвлөгөө					Нийт дүн
		Агаарын хөлөг	Дрон	Үүргийн шүршигч	Гэрлэн урхи	Механик	
1	Архангай	30,000	6,500	6,000			42,500
2	Баянхонгор		3,000	2,000			5,000
3	Завхан	20,000	6,000	7,000			33,000
4	Орхон		1,000				1,000
5	Өвөрхангай	20,000	6,000	7,000			33,000
6	Сэлэнгэ		5,000	6,000			11,000
7	Төв		5,000	7,000			12,000
8	Увс	10,000	5,000	7,000			22,000
9	Хөвсгөл	20,000	5,000	7,000			32,000
10	Хэнтий	10,000	5,000	6,000	8,000	6,000	35,000
11	УБ хотын ногоон бүс	4,000					4,000
12	Богдхан уулын ДЦГ	3,000					3,000
13	Горхи-Тэрэлжийн БЦГ	3,000					3,000
НИЙТ ДҮН		120,000	47,500	55,000	8,000	6,000	236,500

-----oOo-----